

Улаанбаатар Дахь Америк Сургуулийн Элсэлтийн Бодлого

1. Зорилго

- Улаанбаатар дахь Америк Сургууль нь англи хэлний орчинд Олон улсын стандартад нийцсэн боловсролыг олгох зорилго бүхий боловсролын байгууллага юм.
- Улаанбаатар дахь Америк Сургууль нь эцэг эх болон сурагчдийг хүйс, гарал үүсэл, шашин шүтлэг, яс үндсээр нь ялгаварлалгүй, эрх тэгш хандана.
- Улаанбаатар дахь Америк Сургууль нь сурагч бүрийг өөрийн нөөц бололцоогоо бүрэн дайчилж, сурлага, зан байдал, нийгэмшил, соёлын талаар өсөн дэвжих боломжийг олгох тэнцвэртэй, цогц сурах орчныг бүрдүүлэхийг зорино.

2. Элсэлтийн дадал, бодлого

- Сургалт хариуцсан захирал, Сургалт хариуцсан дэд захирлууд сурагчийн элсэлтийн асуудлыг шийдвэрлэнэ.
- Монгол хэл, гадаад хэлнээс бусад бүх хичээл англи хэл дээр явагдана.
- Хүүхдийн сурах бололцоог бүрэн хангах үүднээс нэг ангид байх сурагчдын тоог 24-өөр хязгаарлана.
- Сурагч нь анги алгасан сурах боломжгүй.
- Тус сургуулийн анги дэвшин суралцах сурагчид 4-р сарын 30-ны өдөр хүртэл түрүүлж бүртгүүлэх давуу эрхтэй. Харин суудлын баталгаагаа төлөөгүй, мөн ирэх хичээлийн жилийн Сургалтын гэрээг байгуулаагүй тохиолдолд тухайн сурагчийн суудлын баталгаа хүчингүй болно.
- Элсэлтийн багц материалыг нэг бүрчлэн бүрдүүлсний дараа тухайн хүүхдийг бүртгэнэ. Хэрэв аль нэг материал дутуу бүрдүүлсэн бол бүртгэл хүчингүй болно.
- Элсэлтийн анкетийг буруу бөглөсөн тохиолдолд тухайн хүүхдийг бүртгэхгүй.
- Шаардлагатай бүх төлбөр хийгдсэний дараа тухайн хүүхдийг хичээлд суулгана.
- Эцэг эхчүүдээс анги хуваарилалтын талаар хүсэлт хүлээн авахгүй.
- Нэг гэрийн хоёр хүүхэд Бага болон Дунд сургуульд тус тус элсэн орж байгаа тохиолдолд, элсэлтийн эцсийн шийдвэрийг хоёр сургуулийн захирлууд хамтран гаргана.

3. Элсэлтийн үйл явц

- Америк сургуулиас элсэлтийн материалын багцыг авна.
- Элсэлтийн материалыг гүйцэд бүрдүүлсний дараа Сургалтын албанд хүлээлгэн өгнө.
- Бичиг баримт бүрдэж, бүртгэлийн төлбөр хийгдсний дараа Сургалтын албанаас эцэг эхтэй холбогдож, шалгалтын хуваарийг мэдэгдэнэ.
- Төрөлх хэл нь Англи хэл биш сурагчдын хувьд өмнө нь хаана, ямар сургуульд сурч байснаас үл хамааран Англи хэл дээр түвшин тогтоох элсэлтийн шалгалт авна.
- Сургалт хариуцсан дэд захирал эсвэл сургуулиас томилогдсон эрх бүхий ажилтан элсэлтийн ярилцлагыг сурагчтай хийнэ.
- Тухайн хүүхдийн насны шаардлага хангасан байдал, өмнөх жилийн сурлагын дүн, ярилцлагын болон элсэлтийн шалгалтын дүн тус бүр дээр үндэслэн элсүүлэх шийдвэрийг гаргана.

- Сургалт хариуцсан дэд захирал/Сургалт хариуцсан захирал тухайн ангид сурагчийн орон тоо байгаа тохиолдолд элсүүлэх бичигт гарын үсэг зурж, баталгаажуулна.
- Сургалт хариуцсан дэд захирлын удирдамжийн дагуу Сургалтын албанаас эцэг эхтэй холбогдож, хүүхдийг элсүүлсэн эсэх шийдвэрийг элсэлтийн шалгалт авснаас хойш 24-48 цагийн дотор мэдэгдэнэ.
- Тухайн хүүхдийг элсүүлэх шийдвэр гарсны дараа, Санхүүгийн албатай холбогдож, төлбөр тооцоог нэхэмжлэх ажлыг шийдвэрлэнэ.
- Хуваарилагдсан ангийн багш болон бусад багш нарт шинээр элсэн орж байгаа сурагчийн талаар мэдээлнэ.

4. Хэлний шаардлага

- Манай сургуулиас тавьж буй англи хэлний түвшинг хангасан байх нь сурагч амжилттай сурахын гол үндэс болдог.
- Цэцэрлэг, Бэлтгэл, 1-р ангид элсэгчдэд англи хэлний түвшин шаардлагагүй.
- Англи хэлний нэмэлт туслалцаа шаардлагатай сурагчдыг “Англи хэл хоёрдогч хэл” хөтөлбөрт хамруулна.

5. Элсэлтийн шалгалтын бодлого

- Шинээр элсэж байгаа сурагчдаас Англи хэлний түвшин тогтоох, Математик болон бусад шаардлагатай хичээлээр элсэлтийн шалгалтууд авна.
- Англи хэлтэй орчинд хэдэн жил сурснаас үл хамааран, төрөлх хэл нь англи хэл биш сурагчдаас Англи хэлний түвшин тогтоох шалгалтыг авна.

6. Насны хязгаар болон хичээлийн жилийн дундаас элсэн орох

- Шинээр элсэн орж байгаа сурагч зөвхөн өөрийн насны ангиллын шаардлагыг хангахаас гадна өмнөх ангиа бүрэн дүүргэсэн тохиолдолд тухайн ангид элсэн орно.
- Хичээлийн жилийн хугацаа нь өөр байдаг улсаас ирсэн сурагч /тухайлбал хичээлийн жил нь 1-11-р сар хүртэл үргэлжилдэг/ манай сургуулийн хичээлийн жилийн эхэнд элсэн орж байгаа тохиолдолд сурч байгаа ангиа үргэлжлүүлэн сурна.
- Хичээлийн жилийн дундаас элсэн орж буй сурагч өмнөх сургуульд сурч байсан ангидаа үргэлжлүүлэн суралцана.
- Семестр эхлээд 4 долоо хоног өнгөрснөөс хойш 9-12-р ангид шинээр элсэгчдийг бүртгэн авахгүй.
- Америк сургуулийн үндсэн сурагч дотоодын аль нэгэн сургуульд суралцаж байгаад буцаж ирсэн тохиолдолд бүртгэлийн хураамж төлөх ба мөн элсэлтийн шалгалт өгнө.
- Семестрийн дундуур шинээр элссэн сурагч семестрийн төлбөрийг бүтэн төлнө.

7. Тусгай анхаарал шаардагдах сурагч

- Тусгай анхаарал шаардагдах сурагчийг Сургалт хариуцсан захирлын шийдвэрээр элсүүлнэ. Ингэхдээ тухайн сурагчийн хэрэгцээг сургууль хангаж чадах эсэхийг тогтоосон нөхцөлд элсүүлнэ.
- Тусгай анхаарал гэдэгт хэлний дэмжлэг, сурах бэрхшээл, эрүүл мэндийн дэмжлэг, сахилга болон сэтгэлзүйн дэмжлэг зэрэг орно.
- Сургалт хариуцсан захирал нь тусгай анхаарал шаардагдах сурагчийг элсүүлэхээс татгалзах эрхтэй.

8. Хүлээлгийн жагсаалт

- Элсэлтийн шаардлага хангасан боловч тухайн ангид орон тоо байхгүй тохиолдолд сурагчийг хүлээлгийн жагсаалтад бүртгэж авна.
- Тохирох ангид орон тоо байхгүй үед дээд, доод ангид оруулах боломжгүй.
- Материал бүрдүүлсэн сурагчийг хүлээлгийн жагсаалтанд бүртгэн авч эцэг эхэд мэдэгдэнэ.
- Хүлээлгэнд байгаа сурагчийг өргөдөл өгсөн дараалал болон тухайн сурагчийн өмнөх жилүүдийн сурлагын үзүүлэлт, чадвар зэргийг харгалзан элсүүлнэ.

9. Туршилтын хугацаа

- Шаардлагатай тохиолдолд сурагчид тухайн хичээлийн жилийн туршид туршилтын хугацаа өгнө. Туршилтын хугацаанд тухайн сурагч сурлага, хэлний түвшин, хүмүүжлийн хувьд хоцрогдож байгаа эсэх, сургалт харилцан үр дүнтэй байгаа эсэхийг харна.

10. 2017-2018 оны хичээлийн жилийн сургалтын төлбөр төлөх хугацаа

1-р семестрийн төлбөрийг 2017 оны 8-р 22-ны дотор төлсөн байна.

2-р семестрийн төлбөрийг 2018 оны 1-р сарын 22-ны дотор төлсөн байна.

11. Насанд тавигдах шаардлага

**ШИНЭЭР ЭЛСЭГЧДИЙН НАСАНД ТАВИХ ШААРДЛАГА
2017-2018**

Анги	Төрсөн өдөр:
Pre-Kindergarten	Oct 2012, Nov 2012, Dec 2012, Jan 2013, Feb 2013, March 2013, April 2013, May 2013, June 2013, July 2013, Aug 2013, September 30, 2013
Kindergarten	Oct 2011, Nov 2011, Dec 2011, Jan 2012, Feb 2012, March 2012, April 2012, May 2012, June 2012, July 2012, Aug 2012, September 30, 2012
1st Grade	Oct 2010, Nov 2010, Dec 2010, Jan 2011, Feb 2011, March 2011, April 2011, May 2011, June 2011, July 2011, Aug 2011, September 30, 2011
2nd Grade	Oct 2009, Nov 2009, Dec 2009, Jan 2010, Feb 2010, March 2010, April 2010, May 2010, June 2010, July 2010, Aug 2010, September 30, 2010
3rd Grade	Oct 2008, Nov 2008, Dec 2008, Jan 2009, Feb 2009, March 2009, April 2009, May 2009, June 2009, July 2009, Aug 2009, September 30, 2009
4th Grade	Oct 2007, Nov 2007, Dec 2007, Jan 2008, Feb 2008, March 2008, April 2008, May 2008, June 2008, July 2008, Aug 2008, September 30, 2008
5th Grade	Oct 2006, Nov 2006, Dec 2006, Jan 2007, Feb 2007, March 2007, April 2007, May 2007, June 2007, July 2007, Aug 2007, September 30, 2007
6th Grade	Oct 2005, Nov 2005, Dec 2005, Jan 2006, Feb 2006, March 2006, April 2006, May 2006, June 2006, July 2006, Aug 2006, September 30, 2006
7th Grade	Oct 2004, Nov 2004, Dec 2004, Jan 2005, Feb 2005, March 2005, April 2005, May 2005, June 2005, July 2005, Aug 2005, September 30, 2005
8th Grade	Oct 2003, Nov 2003, Dec 2003, Jan 2004, Feb 2004, March 2004, April 2004, May 2004, June 2004, July 2004, Aug 2004, September 30, 2004
9th Grade	Oct 2002, Nov 2002, Dec 2002, Jan 2003, Feb 2003, March 2003, April 2003, May 2003, June 2003, July 2003, Aug 2003, September 30, 2003
10th Grade	Oct 2001, Nov 2001, Dec 2001, Jan 2002, Feb 2002, March 2002, April 2002, May 2002, June 2002, July 2002, Aug 2002, September 30, 2002
11th Grade	Oct 2000, Nov 2000, Dec 2000, Jan 2001, Feb 2001, March 2001, April 2001, May 2001, June 2001, July 2001, Aug 2001, September 30, 2001
12th Grade	Oct 1999, Nov 1999, Dec 1999, Jan 2000, Feb 2000, March 2000, April 2000, May 2000, June 2000, July 2000, Aug 2000, September 30, 2000